



## ДУНДМАНХАЙДАЙ АУДИТ ХХК

15171 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бакула Ринбүүчийн гудамж, Оршил-2 төв, 5 давхар,  
Утас: 9908 5151, 9199 1462, Факс: (976-11) 32 52 62,  
И-мэйл: byambaahunnu@yahoo.com, Вэб: www.dumaudit.mn

2023 02. 14 № 11  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

## “МАХ ИМПЕКС” ХК-ИЙН ТУЗЫН ДАРГА Г.ЦЭНГҮҮН БОЛОН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ НАРТ

**ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН**  
**Хүлээн авах хаяг:** Монгол Улс, Улаанбаатар хот  
Сонгинохайрхан дүүрэг 18100, 4-р хороо  
Хүнсчидийн гудамж, Өөрийн байр

### Санхүүгийн Тайлангийн Аудитын Талаарх Тайлан Дүгнэлт

Бид 2022 оны 12 сарын 31-ээрх санхүүгийн байдлын тайлан, жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тэмдэглээс бүрдсэн Max Импекс ХК-ний санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний үзэж байгаагаар Max Импекс ХК -ний 2022 оны 12 сарын 31-ээрх санхүүгийн байдал, тухайн жилийн орлогын дэлгэрэнгүй ба мөнгөн гүйлгээ, өмч өөрчлөлтийн тайлангууд нь бүхий л материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Сангийн яамнаас батлан гаргасан заавар журмын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн байна.

### Дүгнэлтийн Үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-уудын дагуу хийж гүйцэтгэв. Бид санхүүгийн тайлангийн энэхүү аудитын ажилд хамаарах ёс зүйн шаардлагуудын дагуу Компаниас хараат бус ба эдгээр шаардлагуудын дагуух ёс зүйн бусад үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Олж авсан аудитын баримт нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай, тохиromжтой гэж итгэж байна.

### Бусад Мэдээлэл

Энэхүү компани нь бусад мэдээлэл буюу үйл ажиллагааны жилийн тайлан бэлтгэдэггүй. Бидний санхүүгийн тайланд өгсөн дүгнэлт нь бусад мэдээлэлд хамаарахгүй ба бид уг мэдээлэлд аливаа баталгаа илэрхийлээгүй. Санхүүгийн тайлангийн аудиттай холбоотойгоор бид бусад мэдээллийг унших үүрэгтэй учраас уг мэдээлэл нь санхүүгийн тайлантай материаллаг байдлын хувьд нийцэж байгаа эсэхийг авч үзнэ. Хэрэв бид хийсэн ажилдаа үндэслэн бусад мэдээлэлд материаллаг буруу тайлагнал байна гэж дүгнэсэн бол энэ байдлыг тайландаа тусгах ёстой. Аудитын явцад бид энэ талаар тайлагнах шаардлага үүссэгүй.

**Үдицдлага болон Засаглах Эрх Мэдэл Бүхий Этгээдүүдийн Санхүүгийн Тайланд хулээх Үүрэг  
Хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайлагналын олон улсын стандартуудын дагуу эдгээр санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах хариуцлага хүлээх бөгөөд мөн залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжтой болгоход зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ. Аудитын явцад бидэнд танилцуулаагүй баримт материалаас үүдэх эрсдлийг компанийн хариуцлага гэдгийг удирдлагад сануулсан болно.

Санхүүгийн тайланг гаргахдаа удирдлага Компанийн үйл ажиллагааг зогсоох юм уу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудаа гаргахдаа удирдлага тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бodoх бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

#### *Санхүүгийн Тайлангийн Аудитад хүлээн Аудиторын Үүрэг Хариуцлага*

Бидний зорилго бол санхүүгийн тайлан нь бүхэлдээ залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийлээс ангид эсэх талаарх ул үндэслэлтэй нотолгоо олж авах, өөрийн дүгнэлтийг илэрхийлсэн аудиторын тайлан бэлтгэх явдал юм.

Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар байгаа материаллаг буруу илэрхийлийг байнга илрүүлдэг гэсэн нотолгоо болохгүй. Буруу тайлагнал нь залилан эсвэл алдаанаас шалтгаалан үүсч болох ба хэрэв тэр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогддог.

Бид засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдтэй аудитын хамрах цар хүрээ, цаг хугацаа, бусад хамааралтай асуудлуудаас гадна аудитаар илэрсэн томоохон чухал асуудлууд болон аудитын явцад ажиглагдсан дотоод хяналтын сул талуудын талаар компаниас ирүүлсэн баримт материалын хүрээнд илэрсэн дутагдал, зорчлийн талаарх асуудлыг зовломжкеөр удирдлагад танилцуулан хүргүүлсэн болно.

#### **Тайлангийн хэрэглээ**

Энэхүү аудиторын тайланг Компанийн тухай хуулийн 94.1, 95.1 дүгээр зүйлүүдэд заасны дагуу компанийн удирдлага, хувьцаа эзэмшигчдэд зориулан бэлтгэсэн. Бид уг тайлангийн агуулгын хүрээнд ажинва нэг туравдагч этээдийн өмнө ямар нэг хариуцлага хүлээхгүй болно.

ДУНДМАН ААНДАЙ АУДИТ ХХК  
УЛААНБААГХОТ ЧД 2 ХОРОО  
БАКУЛА РИНГЧИЙН ГУДАМЖ  
ОРШИЛ 2 ТӨВ 5 ДАВХАРТ  
Огноо: 2023.02.14